



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах,  
нэмэлт оруулах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.1, 15.8.2, 15.8.5, Тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт гаргах комиссын 2022 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 06/22 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр хавсралт ёсоор, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл боловсруулах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах хуулийн этгээдийн жагсаалтыг гуравдугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд нэмэлт ажлын төрөл олгох хуулийн этгээдийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралт ёсоор баталсугай.

4. Тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт үүрэг болгосугай.



Н.ТАВИНБЭХ


170600356

Эрчим хүчний сайдын 2022 оны 08 дугаар  
сарын 05-ны өдрийн А/157 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

Эрчим хүчний эх үүсвэр, шугам, сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт,  
засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг  
шинээр олгох хуулийн этгээдийн жагсаалт

| Д/д                         | Компанийн нэр,<br>регистрийн дугаар                   | Гэрчилгээний<br>дугаар, хугацаа          | Код              | Үйл ажиллагааны төрөл                                                                                                                                 |
|-----------------------------|-------------------------------------------------------|------------------------------------------|------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Цахилгааны чиглэлээр</b> |                                                       |                                          |                  |                                                                                                                                                       |
| 1                           | "Хулансайхан жим"<br>ХХК, 5636086,<br>Баянзүрх дүүрэг | 2182/22<br>2022-08-05-ны<br>өдрөөс 3 жил | ТЗ-2.1           | 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах<br>шугам, дэд станцын угсралт,<br>засварын ажил, түүний туршилт,<br>тохируулгын ажил үйлчилгээ                       |
| 2                           | "Эрчим тайж" ХХК,<br>6860435,<br>Сүхбаатар дүүрэг     | 2183/22<br>2022-08-05-ны<br>өдрөөс 3 жил | ТЗ-6.1<br>ТЗ-6.2 | Өндөр хүчдэлийн хэмжилт,<br>туршилт, тохируулгын ажил<br>үйлчилгээ<br>Реле хамгаалалт автоматикийн<br>хэмжилт, туршилт, тохируулгын<br>ажил үйлчилгээ |


Эрчим хүчний сайдын 2022 оны 08 дугаар  
сарын 05-ны өдрийн А/157 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



Эрчим хүчний эх үүсвэр, шугам, сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт,  
засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн  
хугацааг сунгах хуулийн этгээдийн жагсаалт

| Д/д                         | Компанийн нэр,<br>Регистрийн дугаар              | Гэрчилгээний<br>дугаар,<br>хугацаа       | Код    | Үйл ажиллагааны төрөл                                                                                                                               |
|-----------------------------|--------------------------------------------------|------------------------------------------|--------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Цахилгааны чиглэлээр</b> |                                                  |                                          |        |                                                                                                                                                     |
| 1                           | “Хурцтод од” ХХК,<br>5830931,<br>Хан-Уул дүүрэг  | 1269/22<br>2022-08-05-ны<br>өдрөөс 5 жил | ТЗ-2.1 | 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах<br>шугам, дэд станцын угсралт,<br>засварын ажил, түүний туршилт,<br>тохируулгын ажил үйлчилгээ                     |
| 2                           | “Би Эм Жи Эл” ХХК,<br>5176948,<br>Хан-Уул дүүрэг | 309/22<br>2022-08-05-ны<br>өдрөөс 5 жил  | ТЗ-2.2 | 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах<br>шугам, дэд станцын угсралт,<br>засварын ажил, түүний туршилт,<br>тохируулгын ажил үйлчилгээ                     |
| 3                           | “Эрчимсүлжээ” ХХК,<br>2826038,<br>Хан-Уул дүүрэг | 135/22<br>2022-08-05-ны<br>өдрөөс 5 жил  | ТЗ-2.4 | 0.4-220 кВ болон түүнээс дээш<br>цахилгаан дамжуулах шугам, дэд<br>станцын угсралт, засварын ажил,<br>түүний туршилт, тохируулгын ажил<br>үйлчилгээ |

Эрчим хүчний сайдын 2022 оны 08 дугаар  
сарын 05-ны өдрийн А/157 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт



**Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ, зуух, даралтат сав, шугам хоолойн техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл боловсруулах ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах аж ахуйн нэгж, байгууллагууд**

| Д/д | Компанийн нэр,<br>Регистрийн дугаар                              | Гэрчилгээний<br>дугаар, хугацаа            | Код                  | Үйл ажиллагааны<br>төрөл                                                                                                                                                                                                                                                                                           |
|-----|------------------------------------------------------------------|--------------------------------------------|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | “Электро<br>инженеринг” ХХК<br>(ГХО), 5998549,<br>Хан-Уул дүүрэг | ЗТ-133/22<br>2022-08-05-ны<br>өдрөөс 5 жил | ТЗ-8.2<br><br>ТЗ-8.4 | 0.01-100 МВт болон түүнээс<br>дээш хүчин чадалтай эрчим<br>хүчний эх үүсвэрийн техник<br>эдийн засгийн үндэслэл, зураг<br>төсөл боловсруулах<br>0.4-110 кВ болон түүнээс дээш<br>цахилгаан дамжуулах шугам,<br>дэд станцын барилга<br>байгууламжийн техник, эдийн<br>засгийн үндэслэл, зураг төсөл<br>боловсруулах |

Эрчим хүчний сайдын 2022 оны 08 дугаар  
сарын 05-ны өдрийн А/157 дугаар тушаалын  
дөрөвдүгээр хавсралт

**Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд нэмэлт ажлын төрөл олгох  
аж ахуйн нэгж, байгууллагууд**

| Д/д | Компанийн нэр,<br>Регистрийн дугаар                                                      | Гэрчилгээний<br>дугаар, хугацаа         | Код    | Үйл ажиллагааны төрөл                                                                                                              |
|-----|------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|--------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | “Констракшн<br>инженеринг энд<br>консалтинг сервис”<br>ХХК, 5052599,<br>Сүхбаатар дүүрэг | 2002/20<br>2023-04-13-ны<br>өдөр хүртэл | ТЗ-2.2 | 0.4-35 кВ-ын цахилгаан<br>дамжуулах шугам, дэд станцын<br>угсралт, засварын ажил, түүний<br>туршилт, тохируулгын ажил<br>үйлчилгээ |